



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/176

Шивээговь сум

Ажил хүлээж авах комисс томилох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зорилгоор “Аюулгүйн нөөц бүрдүүлэх” ажлын хүрээнд худалдан авсан 100 шуудай тэжээлийг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

П.Ганжаргал

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Баттуул

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Баярцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнхзаяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, хяналт тавьж ажиллан тайлагнахыг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д, санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа)-д, ажлын тоо ширхэгийн дагуу хүлээн авахыг нярав (Б.Баярцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА